


ЭСГИЙ БА ХЯЛГАС, ШИРХЭГТ




Багшийн заавар

Энэхүү сурагчдын бүлгийн ажил нь 6-14 насны сурагчдад зориулагдсан. Нийт 60-90 минут зарцуулна. Энэхүү дасгалаар сурагчид эсгий урлалын анхан шатны мэдлэг эзэмшиж, ноосоор дөрвөлжин эсгий урлах болно. Сурагчдыг 4 хүнтэй жижиг бүлгүүдэд хувааж дөрвөлжин эсгий хийхийг зөвлөж байна.

ЭСГИЙ ХИЙХ

Хэрэглэгдэх зүйлс:

- Хулсан/сушиний дэвсгэр
- Том тавиур эсвэл жигнэмэгийн цаас (нугалаастай)
- Шүршигч сав, усаар дүүргэсэн
- Нэг ангид 40-60 гр сэмэрхий ноос
- Мяндас эсвэл нэхмэлийн утас
- Хайч
- Ус буцалгагч




Зааварчилгаа:

1. Ус буцалгагчинд ус буцалгаж, шүршигчинд хийнэ.
2. Хулсан дэвсгэрийг тавиур дээр тавина.
3. Хулсан дэвсгэр дээр ноосыг нимгэн үеэр нэг чигт дэвсэж өрнө. Ноос дэвсгэрийг бүрэн бүрхэж нэг давхарга үүсгэсэн байна.
4. Өмнөх алхмыг давтана гэхдээ энэ удаад ноосыг өмнөх давхаргын өрөлтөөс хөндлөн чиглэлд дэвсэж өрнө.
5. Ноосыг шүршигчид байгаа халуун усаар шүршинэ (ус халуун байх ёстой, гэхдээ гар дүрэхийн аргагүй халуун биш).
6. Хулсан дэвсгэрийг доторх ноостой хамт болгоомжтой хуйлна.
7. Хуйлсан дэвсгэрээ (ойролцоогоор 15 см) утсаар ороож, сайтар чангалан уяж бэхлнэ.
8. Хуйлсан дэвсгэрийг гараараа тавиур дотор нааш цааш өнхрүүлнэ.
9. Хэдэн минут тутамд дэвсгэрээ задалж, эсгийн биежилтийг шалгаж, 90 градус хөндлөн эргүүлж тавина. Тэгээд дахин хуйлж, зангидаж, өнхрүүлнэ.
10. Ноосны сэмэрхийг татаж гаргаж болохооргүй цулгай хавтгай болсон бол таны эсгий бэлэн гэсэн үг.

Ноос яаж эсгий болж байна вэ?


Бүх малын үс нүдэнд үл үзэгдэх хайрсаар бүрхэгдсэн байдаг. Дулаан ба чийгний нөлөөгөөр хайрсууд нь бага зэрэг нээгддэг. Хайрс нь дэгээ шиг хэлбэртэй гогцоотой байдаг тул ноосны ширхэгт утаснууд бие биенийхээ хажуугаар нэг чиглэлд гулсаж ороод дэгээгдэн гацдаг. Ноосыг өнхрүүлснээр хайрст хялгаснууд буцаж салахааргүйгээр орооцолдоно. Ингэснээр задгай үс ноос нягт эсгий дэвсгэр болон хувирна.



МАЛ, АМЬТНЫ ҮС

Мал, амьтны үсийг микроскопоор харахад урт хайрслалт ширхэгтэй болохыг харж болно.


Энэ бол микроскопоор хонины үс /ноос/-ийг дурандсан зураг юм.



Үсний зузаан, хайрсны хэмжээ нь хонины үс ноосны шинж чанарыг тодорхойлдог.


Олон барзгар хайрстай зузаан үс нь арьс загатнуулдаг.

Гөлгөр хайрстай нимгэн үс нь зөөлөн мэдрэмж өгдөг.




Хонины бүдүүн, ширүүн үс Хонины нарийн, зөөлөн үс

ЭСГИЙ НЭХМЭЛ



Мал, амьтны үс нойтон болоход хайрс нь тэлж хөөдөг. Үсийг хооронд нь үрэхэд хайрс нь бие биетэйгээ барьцалдаж, хоорондоо орооцолддог. Эсгий ингэж бий болдог. Олон төрлийн малын үсээр эсгий хийж болно.

НЭХМЭЛ ДААВУУ



Зарим мал, амьтны үсийг самнаж, ээрч, нэхмэл эдлэл хийх боломжтой. Харин хонины ноос гэх мэт цөөн төрлийн малын үсээр сүлжмэл эдлэл хийх боломжтой байдаг.

Image attributions for images external to DAIRYCULTURES project:

Horia Varlan, CC BY 2.0 <<https://creativecommons.org/licenses/by/2.0/>>, via Wikimedia Commons

M0tty, CC BY-SA 3.0 <<https://creativecommons.org/licenses/by-sa/3.0/>>, via Wikimedia Commons

Dr. Hugh Manning, CC BY-SA 4.0 <<https://creativecommons.org/licenses/by-sa/4.0/>>, via Wikimedia Commons